



САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ



Japan
Fund for
Poverty
Reduction

Төслийн дугаар: P44112-01
2014 оны 3 дугаар улирлын хэрэгжилтийн тайлан

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

Санхүүгийн Зохицуулах Хороо

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1.** Товч танилцуулга
- 1.2.** Төслийн цаг хугацааны товъёог
- 1.3.** Төслийн зорилт
- 1.4.** Төслийн үр өгөөж

2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БА МЕНЕЖМЕНТ

- 2.1.** Төсөлхэрэгжилтийн зохион байгуулалт
- 2.2.** Төслийн бүтэц болон баг

3. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1. ХЗХ-ДЫН ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЧАДАВХИЖУУЛАЛТ

3.2. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ТУЛГУУРЛАСАН НАСАНД ХҮРЭГСДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ХАНГАМЖ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ АЖЛУУД

- 4.1 ХЗХ-дын чадавхийг бэхжүүлэх хэсгийн хүрээнд
- 4.2 Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролын хүрээнд
- 4.3 Төслийн удирдлага, хангамж, мониторинг үнэлгээний хүрээнд

5. ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ

- 5.1 Төслийн хүрээнд хийгдсэн гэрээнүүдийн жагсаалт

6. ЗАХИРГАА БА САНХҮҮ

- 6.1.** Төслийн үйл ажиллагааны зардал
- 6.2.** Төслийн урьдчилсан данс
- 6.3.** Төслийн кассын тайлан

ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛУУДЫН ЖАГСААЛТ

Нэрс	Байгууллага	Албан тушаал
Э.Энэрэлт	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Хөрөнгө оруулалтын эдийн засагч
Г.Цолмонгэрэл	АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Төслийн шинжээч
Б.Нямаа	Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн улирдлагын газар	Дарга
С.Мягмаржав	Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн улирдлагын газар	Мэргэжилтэн
Х.Бум-Эрдэнэ	Санхүүгийн зохицуулах хороо	Ажлын албаны дарга
Н. Оюунчимэг	Санхүүгийн зохицуулах хороо	Бичил санхүүгийн газрын дарга
Ц.Мягмар-Очир	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв	Гүйцэтгэх захирал
Ш. Гоохүү	Монголын хадгаламж зээлийн хоршоодын холбоо	Тэргүүн

ТОВЧЛОЛ БА ХУРААНГУЙ ҮГС

АХБ	Азийн хөгжлийн банк
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ХЗХ-д	Хадгаламж зээлийн хоршоод
ЯБЯС	Ядуурлыг бууруулах Японы сан
МҮХЗХХ	Монголын үндэсний хадгаламж зээлийн хоршоодын холбоо
МХСМТ	Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТУХ	Төслийн удирдах хороо

ҮГС ИЙН ТАЙЛБАР

text-in – радио, телевизээр цацсан мэдээллийн талаар болон асуултын хариултыг үүрэн утасны мессежээр хүлээн авах

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга

1. Азийн хөгжлийн банк (СЗХ)-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Сангийн яам (СЯ), Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны хооронд байгуулсан 2012 оны 1-р сарын 17-ны өдрийн “Санхүүжилтийнгэрээ”-ний дагуу нийт санхүүжилт 2,912,000 ам.доллар бөгөөд Японы Засгийн Газрын Ядуурлыг Бууруулах Японы Сан (ЯБЯС)-аас 2,5 сая ам.долларын буцалтгүйтусламжаар санхүүжигдэнхэрэгжихээр батлагдсан.

2. АХБ-аас төслийн хэрэгжилтийн хагас жилийн хяналт шалгалтыг 2014 оны 6-р сарын 02-13-ны хооронд хийв. Энэхүү үнэлгээгээр (i) төслийн хэрэгжилтийг үнэлэн үр дүнг зорилгуудад харьцуулах; (ii) төсөлд учирч буй хүндрэлийг тодорхойлж засан сайжруулах төлөвлөгөөг санал болгох, (iii) төсөл хэрэгжүүлэгч болон төсөл гүйцэтгэгч байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр шаардлагатай нөхцөлд төслийн үлдсэн хугацааны хэрэгжилтийн хуваарь, худалдан авалтын төлөвлөгөөг шинэчлэх, (iv) буцалтгүй тусламжийн ашиглалт, зардлын тооцоолол болон санхүүгийн төлөвлөлт, байгуулсан гэрээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон гүйцэтгэлт хяналт тавих, (v) төсөл гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллага, МХСМТ, МХЗХХ зэрэг төслийн оролцогч талуудтай зөвлөлдөх уулзалт хийх, (vi) СЗХ, СЯ-тай төслийн өнөөгийн байдал, үнэлгээний үр дүнг танилцуулах уулзалтыг хийсэн. Ажлын хэсгийн уулзалтын хамтын ажиллагааны санамж бичигт СЯ, СЗХ, АХБ-ны хэлэлцэн тохирсон асуудлуудыг тусгасан ба уг санамж бичиг 2014 оны 6-р сарын 13-ны өдөр 3 тал гарын үсэг зурснаар баталгаажсан.

Төслийн цаг хугацааны товъёог:

Японы Засгийн Газрын төсөл баталсан өдөр:	2010.11.09
АХБ-ны төсөл баталсан огноо:	2010.11.25
Буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурсан өдөр: (БТ-ийн хүчин төгөлдөр болсон хугацаа):	2012.01.17
Төсөл дуусгавар болох огноо:	2016.01.17
Төсөл эхлүүлэх ажлын хэсэг ажилласан өдөр:	2012.06.11-14
Төслийн харилцан ойлголцлын санамж бичигт өөрчлөлт оруулан, үйл ажиллагаатай танилцаж, төсөл шилжүүлсэн.	2012.11.21-22
Төслийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээ	2013.10.14-25
Төслийн хэрэгжилтийн хагас жилийн үнэлгээ	2014.06.02-13

Төслийн зорилт

3. Төслийн зорилт нь хадгаламж, зээлийн хоршоо(ХЗХ)-дыг чадавхижуулах, салбарыг бэхжүүлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар Монгол улсын ядуу болон эмзэг бүлгийн (амьжиргааны түвшингээс арай дээгүүр орлоготой хэдий ч эрсдэлд орж болзошгүй) иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Төслийн хүрээнд:

- (i) шинэ хууль, эрх зүйн дагуу ХЗХ-ны зохицуулалтууд, хяналт-шалгалтын системийн тогтолцоог сайжруулан нэвтрүүлнэ;
- (ii) газар дээрх үзлэг, шалгалт, тусгай зөвшөөрөл, ХЗХ бүрд үнэлгээ зэрэглэл тогтооно;
- (iii) ХЗХ-дын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сургалтын шинэ аргачлалыг нэвтрүүлнэ;
- (iv) насанд хүрэгчдэд санхүүгийн суурь боловсролыг телевизийн цуврал драм, үүрэн утасны мессежээр дамжуулан хүргэнэ;
- (v) гарч ирэх үр дүнг тодорхойлохдоо санамсаргүй түүвэрлэх аргаар нарийвчилсан үнэлгээ хийх болно.

4. Төсөл дараах үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- A. ХЗХ-дын зохицуулалт ба хяналт шалгалт; чадавхижуулалт
- B. Мэдээллийн хэрэгсэл тулгуурласан насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн боловсрол
- C. Төслийн удирдлага, хангамж, зохион байгуулалт ба үнэлгээ

5. Төслийн салбарын бодлого, эдийн засгийн асуудал, эрх зүйн зохицуулалт хариуцсан холбогдох Засгийн газрын эрх бүхий байгууллага, салбарын хөгжлийн бодлогын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлж байна.

Төслийн үр өгөөж

6. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн хэрэгжилт нь 2015 оны 1-р сарын 17-ны өдрөөр дуусгавар болно. Төслийн амжилттай хэрэгжүүлсэн аргаар гарсан үр өгөөж:

Хүснэгт 1. Бүрэлдэхүүн хэсгүүдээс хүлээгдэж буй үр өгөөж

Бүрэлдэхүүн хэсгийн нэр	Хүлээгдэж буй үр өгөөж
A бүрэлдэхүүн хэсэг	
ХЗХ-дын зохицуулалт ба хяналт шалгалт; чадавхижуулалт	<ol style="list-style-type: none">1. Зохицуулалтын журмуудад нийцсэн үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-дын эзлэх хувь хэмжээг 90%-д хүргэнэ.2. Чадавхийн үнэлгээнд хамрагдах ХЗХ-дын эзлэх хувь хэмжээг 90%-д хүргэх ба холбогдох мэдээллээр ХЗХ-дын гишүүдийг хангасан байна.3. ХЗХ-дын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ХЗХ-дын тэргүүлэгчдэд зориулсан олон хувилбар бүхий сургалтын аргачлалын үр өгөөж (суурь 0, зорилтот үр дүн: гурван аргачлалын аль нэг сургалтын аргачлал 50%-д хүрсэн байна)4. ХЗХ байршдаг газар нутгийн хүн амын 50% нь ХЗХ-ны талаар суурь ойлголттой болж, найдвартай үйлчилгээгээр хангагдсан байна.
B бүрэлдэхүүн хэсэг	
Мэдээллийн хэрэгсэл тулгуурласан насанд	<ol style="list-style-type: none">1. ТВ үздэг хүнамын 30% нь санхүүгийн боловсролын цувралыг үзсэн байна.

хүрэгчдэд зориулсан санхүүгийн боловсрол	2. Санхүүгийн боловсролын талаар хиасуултуудад хариу явуулсан өрхийн 50% нь үнэн зөв хариулсан байна. 3. Үзэгчдийн тоо өндөр гарсан газар нутгийн ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өссөн байна. 4. ХЗХ-дын гишүүд болон санхүүгийн боловсролын тухай телевизийн олон ангит цуврал үзэгч нарын ядуурлын түвшин 35%-аар буурсан байна.
С бүрэлдэхүүн хэсэг	
Төслийн удирдлага, хангамж, зохион байгуулалт ба үнэлгээ	1. Зөвлөхүүд сонгон шалгарсан, ажил үүргээ гүйцэтгэсэн байна. 2. Санхүүгийн систем, НББ, санхүүгийн тайлагналт болон, хөндлөнгийн аудитын шалгалтад хамрагдсан байна 3. Төслийн жилийн төлөвлөгөө, зөвлөхүүдийн ажиллах хуваарь, хэрэгжүүлэлтийн тайлагналт системийг нэвтрүүлж өдөр тутмын хэрэгцээнд ашигласан байна 4. Мониторинг үнэлгээний систем нэвтрүүлэн хэрэгжүүлсэн, түүвэрлэлтийн аргаар хийх үнэлгээний ажлын зохицуулалт, дүн шинжилгээ, үрдүнгийн тайлан бүрэн гарсан байна.

2. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ ба МЕНЕЖМЕНТ

Төсөл хэрэгжилтийн зохион байгуулалт

7. ЯБЯС 9152 МОН: “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн нүйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төсөл нь ЯБЯС-ийн санхүүжилтээр АХБ, СЗХ-тай хамтран хэрэгжүүлэх эрт төслийн баримт бичигт тусгагдсан.

8. СЗХ нь ЯБЯС-ийн санхүүжилттэй “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн нүйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хэрэгжүүлэгч агентлаг болно.

9. Төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд нь СЗХ-ны Бичил санхүүгийн газар (БСГ), Монголын Хоршооллын Сургалт Мэдээллийн Төв (МХСМТ), Монголын Үндэсний Хадгаламж Зээлийн Хоршоодын Холбоо (МҮХЗХХ) болно.

10. Төслийн удирдах хороо (ТУХ)-ны бүрэлдэхүүн нь СЗХ, МҮХЗХХ, МХСМТ болон Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо (МХҮНХ)-ны захирлын түвшний төлөөлөгчдөөс бүрдсэн. ТУХ нь төслийн хэрэгжилтийн ерөнхий удирдамж болон стратегийн чиглэлээр удирдлагаар хангаж ажиллаж байна. ТУХ-ны бүрэлдэхүүнд:

1. СЗХ-ны Ажлын албаны дарга бөгөөд ТУХ-ны дарга Х.Бум-Эрдэнэ,
2. СЗХ-ны БСГ-ны дарга бөгөөд Төслийн захирал Н.Оюунчимэг,
3. МҮХЗХХ-ны дарга Ш.Гоохүү,
4. МХҮНХ-ны тэргүүлэгч гишүүн Ч.Алтангааяа
5. МХСМТ-ийн гүйцэтгэх захирал Ц.Мягмар-Очир,
6. Сангийн яам (СЯ)-ны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Санхүүгийн захзээл, даатгалын хэлтсийн захирал Н.Түвшинжаргал,
7. СЯ-ны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын мэргэжилтэн С.Мягмаржав

11. 2014 оны 3 дугаар улиралд ТУХ 2 удаа хуралдаж төслийн мэдээллийн хэрэгсэлд тулгуурласан насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг сайжруулах хүрээнд бүтээгдэж байгаа телевизийн олон ангит уран сайхны киноны зохиолыг хэлэлцэн баталж, зураг авалтанд шилжүүлээ.

2.2. Төслийн бүтэц болон баг

12. Төслийн дунд хугацааны үнэлгээний үр дүнд Төсөл хэрэгжүүлэх нэгж төслийн зохицуулагч, санхүү, худалдан авалтын ажилтан, нарийн бичиг/орчуулагч гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан Төслийн захирлын шууд удирдлага дор ажиллаж байна.

13. Мониторинг үнэлгээний олон улсын зөвлөхажилдаа орж, мониторинг үнэлгээний баг бүрдсэн.

14. Олон нийттэй харилцах үндэсний зөвлөх Д.Гэрэлт-Од, Санхүүгийн боловсролын судлаач Д. Дамдинжав нар санхүүгийн боловсрол олгох олон ангит уран сайхны кинонд санхүүгийн мессежүүдийг хэрхэн тусгах талаар болонолон ангит киноны үйл явдалын дараалал, өрнөл, дүрүүдийн хөгжил зэрэгт өөрсдийн санал, зөвлөмжөө өгч уран бүтээлийн багтай хамтран ажиллаж байна. Олон нийттэй харилцах мэргэжилтэн төслийн олон нийттэй харилцах төлөвлөгөөг боловсруулж, төслийн танилцуулга брошурыг хэвлэн 2014 оны 9 сарын 25-30нд зохион байгуулагдсан JFPR үзэсгэлэнгийн үеэр тараагдлаа. Бусад танилцуулах материалын агуулга дизайныг боловсруулах ажил хийгдэж байна.

15. Санхүүгийн боловсролын судлаач олон ангит киноны зохиолд санхүүгийн мессежүүдийг хэрхэн тусгах талаар болоод маркетингийн төлөвлөгөөг зохиолчид тайлбарлах түүнчлэн санхүүгийн мессеж кино зохиолд хэрхэн туссан холбоосыг мониторинг үнэлгээний багт танилцуулан ажиллаж байна.

3.ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Бүрэлдэхүүн хэсэг А: ХЗХ-ДЫН ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ; ЧАДАВХИЖУУЛАЛТ

ЗОХИЦУУЛАЛТ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Зохицуулалтын журмын хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа.

16. ХЗХ-дынзохицуулалтынэрхзүйнорчин, нягтланбодохбүртгэл, дотоодхяналтшалгалтынталаарбүх ХЗХ-дыгхамруулан бүсчилсэн 5 удаагийн хэлэлцүүлэг, сургалтыг Улаанбаатар хотод 2, Орхон, Дундговь, Увс аймгуудад амжилттай зохион байгуулж, нийт 136 ХЗХ-ны 348 удирдах ажилтан сонгуультанууд оролцсон.

17. Төслийн хүрээнд тогтворжилтийн үйлчилгээ, хадгаламж хамгаалалын тогтолцоо, хадгаламжийн даатгал, ХЗХ-ны хадгаламж зээлийн үйл ажиллгаанаас бусад эрхлэх үйлчилгээндолон улсын шилдэг туршлагааснэвтрүүлэх арга замыг тодорхойлох, манай улсын ХЗХ-ны хуульд хэрхэн нийцүүлэх арга замыг боловсруулж холбогдох хууль тогтоомж болон журам зааварт оруулж, уялдаа холбоог хангах чиглэлээр зөвлөмж гаргуулахаар зохицуулалтын зөвлөх ажиллуулсан ба эхлэлтийн тайлан болон явцын тайлан ирүүлсэн. Зохицуулалтын зөвлөхөөс боловсруулсан санал зөвлөмжийг оролцогч талуудаар хэлэлцүүлнэ.

ХЗХ-дын зайны болон газар дээрх хяналт шалгалт

18. Олон улсын зөвлөх Брайны өгсөн зөвлөмжийн хүрээнд боловсруулсан хянан шалгалтын гарын авлагын дагуу 2014 оны 3-р улирлын байдлаар газар дээрх хяналт шалгалтыг 25 ХЗХ, эрсдэлд суурилсан үзлэгийг нийт 28 ХЗХ-д хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

19. Тайлант улиралд нийт ХЗХ-ны 98,6 % буюу 137 ХЗХ санхүүгийн болон зохистой харьцааны тайлангаа хугацаанд нь ирүүлсэн байна.

20. ХЗХ-дод нэвтрүүлэх нягтлан бодох бүртгэлийн програмыг тохируулан нэвтрүүлэх гүйцэтгэгч шалгарсан ба уг программыг тохируулан нэвтрүүлэх болон дараах үйлчилгээ түүний төлбөр тооцоотой холбоотой асуудлаар хэлэлцээр хийгдэж байна.

21. Эрсдэлд суурилсан хяналт үнэлгээ сэдвээр бичил санхүүгийн газрын байцаагч, хянан шалгагч нарыг чадавхжуулах 3 өдрийн сургалт зохион байгууллаа.

ХЗХ-НЫ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ, СУРГАЛТ

22. ХЗХ-дыг чадавхижуулахад сургалтын 2-3 аргыг туршихаар төслийн баримт бичигт тусгасны дагуу зайны сургалтын арга хэлбэрүүд болон Монголд тэдгээр арга хэлбэрүүдийг ашиглаж буй байдал, байгууллага тэдгээрийн туршлагын талаарх танадалтыг МХСМТ-ийн ажилтнууд гүйцэтгэсэн.

23. Сургалтын модулийг танхимын болон интернетэд суурилсан байдлаар боловсруулж нийт ХЗХ-ын 96% ба орон нутгийн ХЗХ-дыг 100% хамруулан 974 удирдлага сонгуультаныг оролцуулан зохион байгуулсан.

24. ХЗХ-дын үйл ажиллагаанд дагаж мөрдөх бодлого журмын үлгэрчилсэн гарын авлагыг боловсруулан ном хэлбэрээр хэвлүүлж, нийт 124 ХЗХ-д тараалаа.

25. ХЗХ-дын чадавхийн 2 дахь үнэлгээг хийх удирдамж хуваарийг боловсруулан, 2014 оны 6 сард үнэлгээг эхлүүлж, 2014 оны 9-р сарын 30-ны байдлаар нийт ХЗХ-дын 50,3% 2 дахь удаагийн үнэлгээнд хамрагдсан байна.

Бүрэлдэхүүн хэсэгВ:МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ТУЛГУУРЛАСАН НАСАНД ХҮРЭГСДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

26. Дэлхийн банкны судалгааны аргачлалын дүн шинжилгээ, фокус бүлгийн ярилцлага, судалгаа дээр мэдээллийн хэрэгцээг гаргаж, санхүүгийн боловсролын мессежийг түгээхэд шаардагдах зардал ба сувгийн хүртээмжийг тодорхойлж насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг сайжруулах “Маркетингийн төлөвлөгөө” боловсруулсан.

27. Туршилтын эхний 2 ангийг бүтээж, фокус групп болон мэргэжлийн үнэлгээг хийлгэж, киног үргэлжлүүлэн бүтээж, олон нийтийн хүртээл болгохоор зорьж байна.

28. Кино зохиолын чанарыг сайжруулах, гарч болох алдаанаас сэргийлэх зохиолчид туслуулах зорилгоор редактор ажиллуулав.

29. Кино зохиолын 3-10-р ангийг ТУХ-ны хурлаар 2 удаа хэлэлцэн сайжруулж, зураг авалтад шилжүүлсэн ба 3-10-р ангийн зураг авалт дуусч, эвлүүлэгийн ажил хийгдэж байна.

Төслийн үйл ажиллагаа, үр дүнг олон нийтийн хүртээл болгох нь

30. Монгол улсад ХЗХ үүсэж, хөгжсөн түүхийг өгүүлсэн баримтат киноны зохиол боловсруулагдаж, зураг авалтын ажил дууссан ба эвлүүлэгийн ажил хийгдэж байна.

31. ХЗХ-ны хөгжлийн явц, өнөөгийн байдал, зохицуулалтын талаар товхимол боловсруулан, хэвлэж JFPR үзэсгэлэнгийн үеэр олон нийтэд тараагдсан ба нийт ХЗХ-д түгээх ажил эхэллээ.

32. Төслийн хүрээнд ХЗХ-ны эрх зүйн орчин, төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон салбарын ач холбогдлын талаар сурталчлах СЗХороо, ХЗХ-ны төлөөлөл оролцсон шууд нэвтрүүлгийг зохион байгуулахаар зохиол бичигдсэн.

33. Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарч байгаа нааштай үр дүнгүүдийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор төслийн олон нийттэй харилцах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, төслийн танилцуулга брошур хэлбэрээр хэвлэгдэн олон нийтэд түгээгдэж байна.

34. АХБ-наас 2014 оны 9 сарын 25-30-ний хооронд зохион байгуулсан JFPR төслүүдийн өдөрлөгт идэвхтэй оролцож, төслийн үйл ажиллагаа, үр дүнг оролцогчдод танилцуулж сурталчилсан.

Бүрэлдэхүүн хэсэгС: ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ХАНГАМЖ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ҮНЭЛГЭЭ

35. Төслийн баг төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төслийн тусгайболонүйлажиллагааныдансыгСЯ, АХБ-ны зөвшөөрөлтэйгээрТөрийнбанкиндбайршууланашиглажбайна.

36. ТУХ-г 2014 оны 3-р улиралд 2 удаа хуралдуулж, насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг

сайжруулах зорилгоор бүтээгдэж байгаа олон ангит уран сайхны киноны зохиолыг хэлэлцүүлэн, батлуулж зураг авалтад шилжүүлээ.

37.

ТУХ-

оосгаргасанажлындирдамжийндагуутөслийнбүрэлдэхүүнхэсэгтусбүрийнтөлөвлөгөөтажлуудыгхолобогдох байгууллагууд, зөвлөхүүдээсшаардан, хариуцсанмэргэжилтнүүдтэйхамтран гүйцэтгэхэд ложистик ажиллагаагаар хангаж ажиллаж байна.

38. Төслийн захирал төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төслийн хэрэгжилтийн хуваарь, гүйцэтгэлийн талаар төслийн нэгжийн ажилтнууд, зөвлөхүүдээс танилцуулга авч, үүрэг өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

39. Мониторинг үнэлгээний баг дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Үүнд:

- ХЗХ-дын чадавхийнүнэлгээ, сургалтдэдбүрэлдэхүүнхэсгийнхүрээнднийт30 хоршоог түүвэрлэн үнэлгээ хийхээр бүсчилсэн байдлаар сонгосон. ХЗХ-дын сургалт чадавхижуулалтын дэд бүрэлдхүүн хэсгийн үнэлгээний мэдээлэл цуглуулах аргачлал, арга зүйг боловсруулах шатанд явж байна.
- Мониторинг Үнэлгээний багийн олон улсын зөвлөх сонгогдон ажлаа эхэлсэн.
- Мониторинг үнэлгээний үндэсний зөвлөх үүрэн сүлжээний оператор (Unitel, G-Mobile болон Mobicom) компаниудтай уулзаж, ТВ-ийн олон ангит киноны явцад смс-ээр хийх судалгааны текст системийг гаргах, турших, үйл ажиллагааны горимд оруулахад шаардлагатай мэдээлэл авсан. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой програм хангамжийн компаниудтай уулзаж, тэдгээрийн үнийн санал, техникийн саналыг хүлээн авсан.
- Смс судалгааны ажлын даалгавар, төсвийг боловсруулж эцэслэсэн. АХБ-аас зөвшөөрөл авахаар хүлээж байна.
- 2014 оны 8 дугаар сард ХЗХ-дын буй чадавхийн үнэлгээний үеэр Төв, Увс аймгийн нийт 6 ХЗХ-дод мониторинг хийн, үнэлгээний үйл явцтай газар дээр биечлэн танилцаж мэдээлэл солилцсон.
- Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх бүрэлдхүүн хэсгийн хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролын түвшин, зан үйлийг тодорхойлох, хэмжих зорилготой санхүүгийн боловсролын суурь судалгааны асуулгыг эхний байдлаар боловсруулсан. Олон ангит киноны зохиолын хянан сайжруулсан хамгийн эцсийн хувилбар Төслийн Удирдах Хороогоор батлагдсаны дараа судалгааны асуулгыг эцэслэн, санхүүгийн боловсролын мессеж, киноны утга агуулгатай нийцэж буй байдлыг эргэн харж нягтлан үзнэ.

4. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ АЖЛУУД:

40. ХЗХ-дын зохицуулалт ба хяналтын системийн хүрээнд

- ХЗХ-дод эрх зүйн орчин, зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжөөр 5 бүсэд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгийн үр дүнг нэгтгэн зохицуулалтын журмуудыг шинэчлэн боловсруулж батлуулана.
- ХЗХ-дод газар дээрх хяналт шалгалт болон үзлэгийг хуваарийн дагуу 2014-2015 онд хийж дуусгана.

41. ХЗХ-дын чадавхийг бэхжүүлэх хүрээнд:

- ХЗХ-дод чадавхийн 2 дахь үнэлгээгУлаанбаатар хотын ХЗХ-д хийж дуусган, үнэлгээний тайлан боловсруулж танилцуулна.
- Дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн интернэтэд суурилсан сургалтын модулийг баяжуулж, ХЗХ-дын зохицуулалтын талаарх сайн туршлага судлах 5 бүсийн сургалтыг бүх ХЗХ-с 2 төлөөлөгч оролцуулан зохион байгуулна.
- ХЗХ-дын 2 дахь чадавхийн үнэлгээний үр дүнгээр нэмэлт чадавхжуулалт шаардлагатай хоршоодод бойжуулах сургалт зөвлөгөөг газар дээр хийнэ.

- ХЗХ-дод санхүү бүртгэлийн программ нэвтрүүлж, FINA-өөрчлөгдөж тайлан гаргахтай холбоотой сургалтыг бүх ХЗХ-дын төлөөлөлийг оролцуулан зохион байгуулна.
- ХЗХ-ны хөгжлийн тухай баримтат киног олон нийтийн хүртээл болгоно.
- ХЗХ-дын үндэсний чуулга уулзалт зохион байгуулна.
- Телевизийн шууд ярилцлага хийх, мэдээллийн хэрэгсэлээр иргэдийн ХЗХ-ны итгэлийг сэргээх мэдээлэл цацна.

42. Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:

- Телевизийн 26 ангит уран сайхны киног бүтээж, орон даяар цацалттай телевизийн сувгаар дамжуулан олон нийтийн хүртээл болгоно.
- Киногоор иргэдэд хүрсэн санхүүгийн мэдээлэл, мэдлэгийг үнэлнэ.
- Үнэлгээний үр дүнд үндэслэн санал боловсруулна.
- Санхүүгийн зохицуулах хорооны бүх нийтийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөртэй уялдуулан сургалт хийх, хөтөлбөр болон танилцуулгыг хэвлэн тараана.

43. Төслийн удирдлага, зохион байгуулалт, мониторинг үнэлгээбүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:

- Төслийн олон нийттэй харилцах төлөвлөгөөний дагуу ханын болон ширээний каледарь, тэмдэглэлийн дэвтэрийн агуулга, дизайныг эцэслэн хэвлүүлэх.Төслийн видео танилцуулгыг хийх.
- Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролын түвшин, зан үйлийг тодорхойлох, хэмжих зорилготой санхүүгийн боловсролын суурь судалгааны асуулгыг турших
- Насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролын суурь судалгааны асуулгыг эцэслэх, Төслийн Удирдах Хороонд танилцуулж батлуулах
- Насанд хүрэгчдийн санхүүгийн суурь судалгаа хийхтэй холбоотой судлаачдын багийн сургалтын хөтөлбөр, сургалтын модул боловсруулах
- Насанд хүрэгчдийн санхүүгийн суурь судалгаа хийхтэй холбоотой судлаачдын баг бүрдүүлж сургах
- 2014 оны 11-р сард насанд хүрэгчдийн санхүүгийн суурь судалгааг эхлүүлэх
- Смс-ээр хийх судалгааны програм хангамжийг хөгжүүлэх, текст систем турших дотоодын компанийг гэрээлэх, Азийн Хөгжлийн Банкнаас зөвшөөрөл авах
- Смс-ээр хийх судалгааны текст систем, програм хангамжийг хөгжүүлэх, турших, үйл ажиллагааны горимд оруулах
- Смс судалгааны санхүүгийн боловсролын функционал тест боловсруулах, турших, утсаар хийгдэх судалгааны асуулга боловсруулах, турших
- Насанд хүрэгчдийн санхүүгийн суурь судалгааны чанарын үнэлгээний мониторинг/судалгааны чанарын хөндлөнгийн үнэлгээний ажлын даалгавар, төсвийг АХБ-руу явуулж батлуулах
- ХЗХ-дын сургалт чадавхижуулалтын дэд бүрэлдэхүүн хэсгийн чадавхийн үнэлгээний мэдээлэл цуглуулах аргачлал, арга зүйг боловсруулан турших, үнэлгээний арга зүйг Төслийн Удирдах Хороонд танилцуулж батлуулах
- ХЗХ-дын сургалт чадавхижуулалтын дэд бүрэлдэхүүн хэсгийн чадавхийн үнэлгээний мэдээлэл цуглуулах судлаачдыг сургах сургалтын хөтөлбөр боловсруулах
- ХЗХ-дын сургалт чадавхижуулалтын дэд бүрэлдэхүүн хэсгийн чадавхийн үнэлгээний мэдээлэл цуглуулах судлаачдын багийн бүрэлдхүүнийг сонгох, сургах
- ХЗХ-дын сургалт чадавхижуулалтын дэд бүрэлдэхүүн хэсгийн чадавхийн үнэлгээний мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлэх, сургалт чадавхижуулалтын үр дүнг хэмжих, тодорхойлох үнэлгээ хийх

- ХЗХ-дын 2014 оны 4 улиралд дуусгахаар төлөвлөгдөж буй чадавхийн үнэлгээний үеэр мониторинг хийх, үнэлээчидтэй мэдээлэл солилцох
- Түүвэрт орсон 30 ХЗХ-ны 2011 оноос хойшх тоон мэдээлэлийг СЗХ-ны тайлангаас түүвэрлэн авч, гүйцэтгэлийг гаргах
- ХЗХ-ны эрх зүйн орчны өөрчлөлттэй холбогдох баримт бичгийн судалгааг хийж гүйцээх, холбогдох гүйцэтгэлийг гаргах

5. ТӨСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ

1. ХЗХ-дын нягтлан бодох бүртгэлийн программын худалдан авалт

2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 10.00 цагт Санхүүгийн зохицуулах хорооны 209 тоот өрөөнд төслийн удирдах хорооны дарга Х.Бум-Эрдэнээр ахлуулан ХЗХ-дын хэлтсийн дарга Б.Пүрэв, бодлогын хэлтсийн дарга А.Баянмөнх, мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн Д.Бадрал, бодлогын хэлтсийн хянан шалгагч Л.Цогцэнгэлийн бүрэлдэхүүнтэй хурлыг эхлүүлэв. Үнэлгээний хороог төслийн захирлын 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 11/14 тоот тушаалаар томилсон.

Нийт “Ординат” ХХК, “Инфосистемс” ХХК, Grape City” ХХК, “Diverse” ХХК, Interactive” ХХК гэсэн 5 байгууллага руу үнийн санал ирүүлэх урилгыг 7 дугаар сарын 1-ний өдөр хүргүүлэн 7 дугаар сарын 16-ны өдөр “Инфосистемс” ХХК, “Grape City” ХХК, “Diverse” ХХК гэсэн 3 компаниас санал ирүүлсэн.

Ирүүлсэн үнийн саналыг жагсаавал:

“Инфосистемс” ХХК	191,000,000₮
“Grape City” ХХК	88,000,000₮ /НӨАТ-ын дүн орсон/
“Diverse” ХХК	305,200,000₮

Дээрх материал ирүүлсэн 3 компаниас программд тавьсан шаардлагыг ханган хамгийн бага үнийн саналыг “Grape City” ХХК ирүүлэн Азийн хөгжлийн банкнаас тус компанитай төгрөгөөр гэрээлэхийг зөвшөөрсөн албан бичгийг 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан.

2. Оффисын тавилгын худалдан авалт

1. Төслийн худалдан авалтын төлөвлөгөөний дагуу оффисын хэрэглээнд 1 шкаф, 2 тумбочка худалдан авах ёстой байсныг 9 дүгээр сарын 23-ны өдөр шкафын үнийн саналыг дараах 3 байгууллагаас хүлээн авч BSB trading ХХК хамгийн бага саналыг ирүүлсэн

No.	Description	BSB trading	UBOS Co.,ltd	ITZONE
1.	Filing cabinet			
	Unit price	479,900	522,727.3	550,000
	Total amount (without VAT)	479,900	523,363.3	550,000
	Total amount in USD	260.96	284.25	299.08

2. Хоёр тумбочканы үнийн саналыг дараах 3 байгууллага ирүүлснээс ANUN ХХК хамгийн бага үнийн санал ирүүлж худалдан авалтыг гүйцэтгэсэн.

No.	Description	BSB trading	ANUN Co.,Ltd	ITZONE
1.	Filing cabinet			
	Unit price	349,900	322,000	357,000
	Quantity	2	2	2
	Delivery price	15,000	0	
	Total amount (without VAT)	714,800	644,000	714,000
	Total amount in USD	388.70	350.20	388.26

6. САНХҮҮ

6.1 Төслийн үйл ажиллагааны зардал

Хүснэгт 3. Зардлын хуваарилалтба зарцуулагдсан зардал (2014 оны 9-р сарын 30-ны байдлаар)

№	Зардлынтөрөл	Хэмжихнэгж	Төсөв	Гүйцэтгэл
1. Шуудан, холбоо, интернетийнзардал				
1.1	Телефонугас/	улирал	450,000.00	168,212.10
1.2	Интернет (Gmobile 2mb)	улирал	983,400.00	655,600.00
1.3	Буухиашуудан (100гр)	улирал	600,000.00	40,560.00
Дүн			2,033,400.00	864,372.10
2. Бичигхэргийнзардал				
2.1	Бичгийнцаас А4	улирал	1,020,000.00	383,200.00
2.2	Хувилагчийнхор Canon 2520	ш	765,000.00	456,000.00
2.4	Бичгийнхэрэгсэл, компьютерзасварүйлчилгээболоноффисийнхэрэгцэ, хангамжийнзардал	бөөн	4,500,000.00	1,022,148.00
2.5	Хурал, уулзалт, хэлэлцүүлгийнзардал	бөөн	1,800,000.00	306,100.00
Дүн			8,085,000.00	2,167,448.00
3.Ажлын байрнытүрээс				
3.1	Түрээс 25м/кв	м/кв	6,375,000.00	11,719,046.20
Дүн			6,375,000.00	11,719,046.20
4. Автомашинытүрээсийнзардал				
4.1	Автомашинытүрээс/Улаанбаатархотод	сар	1,500,000.00	400,000.00
Дүн			1,500,000.00	400,000.00

Нийтдүн		<u>17,993,400.0</u> <u>0</u>	<u>15,150,866.3</u> <u>0</u>
---------	--	---------------------------------	---------------------------------

6.2 Төслийн урьдчилсан данс

10. Төслийн баг төслийн тусгай данс болон төслийн үйл ажиллагааны зардлыг зарцуулах дэд дансыг Төрийн банк дээр нээн үйл ажиллагааг тогтвортой явуулж байна.

Хүснэгт 9. Төслийн урьдчилсан сангийн данс (2014 оны 9-р сарын 30-ны байдлаар)

Дэд дансны баланс (MNT-34000372090)	62,614,855.37
Тусгайдансныбаланс(USD-34000372080)	140,767.17
Үйл ажиллагааны дансны баланс (MNT-3400038460)	13,848,438.51
2014 оны 3-р улирлын дэд дансны нийт зарцуулалт (MNT)	114,280,001.94
Нийт нөхөн дүүргэлтийн дүн (USD)	133.110.68